



Хорио цээрийн дэглэм гэж юу вэ?

Хорио цээрийн дэглэмийн үед КОВИД-19 халдварыг үүсгэгч SARS-CoV-2 вирус халдсан байж болох хүнийг бусдаас хол байлгадаг.

Тусгаарлана	<ul style="list-style-type: none"> Вакцин хийлгээгүй; ЭСВЭЛ Вакцин хийлгэсэн боловч нэмэлт тун хийлгэх боломжтой ч гаа хараахан хийлгээгүй 	<ul style="list-style-type: none"> КОВИД-19 өвчний халдвар авсан хүнтэй хамгийн сүүлд харьцсаны дараа доод тал нь 5 хоног гэртээ байгаарай. Хэрэв танд шинж тэмдэг илрэхгүй, 5 эсвэл түүнээс хойших хоногт шинжилгээ өгөхөд сөрөг хариу гарвал 5 дахь хоногийн дараа хорио цээрийн дэглэмээ дуусгаж болно. <ul style="list-style-type: none"> Хэрэв шинжилгээний хариу эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг дагаж мөрдөнө үү. Шинжилгээ өгөх боломжгүй эсвэл шинжилгээ өгөхгүй гэж шийдвэл 10 дахь хоног дуустал хорио цээрийн дэглэм барих нь зүйтэй. Нийт 10 хоног бусдын дэргэд, ялангуяа өрөө тасалгаанд амны хаалт зүүнэ үү. Хэрэв танд шинж тэмдэг илэрвэл гэртээ байж, боломжтой бол шинжилгээ өгнө үү. Хэрэв та шинжилгээ өгч чадахгүй эсвэл хариу нь эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг дагаж мөрдөөрэй.
Тусгаарлахгүй	<ul style="list-style-type: none"> Нэмэлт тун хийлгэсэн; ЭСВЭЛ Вакцин хийлгэсэн боловч нэмэлт тун хийлгэх шалгуур хараахан хангаагүй 	<ul style="list-style-type: none"> 5 дахь өдөр шинжилгээ өгнө. <ul style="list-style-type: none"> Хэрэв шинжилгээний хариу эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг дагаж мөрд. Бусдын эргэн тойронд, ялангуяа өрөө тасалгаанд 10 хоногийн турш сайн таарсан амны хаалт зүүгээрэй (нэмэлт мэдээллийг доорх амны хаалт зүүх зааварчилгаанаас үзнэ үү). Хэрэв танд шинж тэмдэг илэрвэл гэртээ байж, боломжтой бол шинжилгээ өгнө үү. Хэрэв та шинжилгээ өгч чадахгүй эсвэл хариу нь эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг дагаж мөрдөнө үү.

****Ажлын байрны орчин** (эрүүл мэндийн ажилтанд хамаарахгүй): Вакцин хийлгэсэн, нэмэлт тун хийлгэх боломжтой боловч хараахан хийлгээгүй хүмүүс өвчний шинж тэмдэг илрээгүй бол ажилдаа эргэн орж болно.

- КОВИД-19 халдвартай хүнтэй хамгийн сүүлд харьцсанаас хойш 3-5 хоногийн дотор шинжилгээний хариу **сөрөг** гарна.

Нэмэлт тун хийлгэх боломжтой тодорхойлолтыг энэ холбоосноос үзнэ үү: www.bit.ly/Vx-Eligible

Тайлбар:

Дээрх удирдамжид ӨХТ, КНЭМГ (Калифорнийн Нийгмийн Эрүүл Мэндийн Газар)-ын хамгийн сүүлийн үеийн зөвлөмжийг тусгасан. 5 хоног өнгөрсний дараа халдвар дамжих эрсдэлтэй байж болох ч эдгээрийг та ашиглаж болно. 10 хоногийн турш бусдаас хол тусгаарлах нь хамгийн аюулгүй сонголт хэвээр байна.

Амны хаалт зүүх заавар:

Халдвар авснаас хойш 10 хоног өнгөртөл бусдыг хамгаалахын тулд сайн таарсан маск зүүх нь маш чухал. Амны хаалтыг хэрхэн хамгийн үр дүнтэй хэрэглэх талаар мэдээлэл авахыг хүсвэл энэ холбоосыг үзнэ үү.

<https://www.cdph.ca.gov/Programs/CID/DCDC/Pages/COVID-19/Get-the-Most-out-of-Masking.aspx>



**ALAMEDA COUNTY HEALTH CARE SERVICES AGENCY
PUBLIC HEALTH DEPARTMENT**

Colleen Chawla – Agency Director
Kimi Watkins-Tartt – Director
Nicholas Moss, MD – Health Officer

Contact
Public Health Department:
(510) 267-8000 Main Line
COVID-19 Information:
(510) 268-2101

www.acphd.org

Шинэчлэв:
2022.01.14